



**ДАЙЧИН ГҮРНИЙ ДОТООД  
ЯАМНЫ МОНГОЛ  
БИЧГИЙН ГЭРИЙН ДАНС**


МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэнгээс “ДАЙЧИН ГҮРНИЙ ДОТООД ЯАМНЫ МОНГОЛ БИЧГИЙН ГЭРИЙН ДАНС” 9 боть номыг эрхлэн хэвлүүлээ.

Тус бүтээлд манж хэлээрх 1742 баримтын галиг, орчуулга, монгол бичгээрх 1512 баримтын галиг, хөрвүүлэг, төвдийн шар үсгээрх 9 баримтын сийрүүлэг галиг, орчуулга, тод үсгээрх 41 баримтын галиг, хөрвүүлэг, хятад хэлээрх 3 баримтын орчуулга болон газар орон, хүний нэр, хэргэм зэрэг, эртний үг хэллэгийн 1600 орчим тайлбар багтжээ.

Бээжинд хадгалагдаж буй эл архивын баримтууд нь XVII зууны хоёрдугаар хагас, XVIII зууны эхэн үеийн Монгол(Халх ба Ойрд), Манж, Төвд, Оросын харилцаа, түүхэн ээдрээт нөхцөл байдал, тус тусын баримталсан бодлого, хэрэгжүүлсэн үйл

ажиллагааг нарийвчлан судлахад нэн чухал агаад үл давтагдах, түүхэн эх сурвалж болох төдийгүй XVII зууны үеийн монгол бичгийн хэлний онцлог, монгол хэлний үгийн утга, хувьсал, орчуулгын уламжлал зэргийг шинжлэн судлах үнэт хэрэглэгдэхүүн юм.

Энэхүү эмхэтгэлээс тухайн цаг үед Монголын хамаатай хэргээр Манжийн хаадын буулгасан зарлиг, Өндөр гэгээн Занабазар, Түшээт хан, Сэцэн хан тэргүүтэй Халхын хан, ноёд, Галдан бошогт, Цэвээнравдан болон Ойрдын ихэс дээдэс хийгээд Далай лам, Банчэн эрдэнэ тэргүүтэн Төвдийн хутагт хувилгаад, Оросын хаант засгаас Чин улсад илгээсэн түүхэн харилцааны бичгүүдтэй танилцах болно.



**СОЁЛЫН ҮГ ХЭЛЛЭГИЙН ТОВЧ  
ТАЙЛБАР ТОЛЬ** (Сэндэнжавын Дуламын Цагаан сарын бэлгэдэл номын жишээгээр). Уб., МУИС Пресс хэвлэлийн газар. 2017. 210 х. ISBN: 978-99978-58-19-1

МУИС-ийн Судалгааны санхүүжилтээр Даяаршилба Монголын цагаан сарын соёлын өөрчлөлт төслийн хүрээнд Д.Отгонтуяа, Г.Нандинбилиг, Д.Нямдорж нар гүйцэтгэж орчуулгыг Б.Уранбаясгалан, Томас Күк, Жоанна Долинска нар хянажээ.

С.Дуламын Цагаан сарын бэлгэдэл номд тулгуурлан монгол, англи хэлээр туурвисан энэхүү товч тайлбар тольд

- Цагаан сарын соёлын товч тайлбар толь
- Цагаан сарын соёлын 400 орчим үг хэллэг
- Монгол соёлын 700 орчим үг хэллэг
- Цагаан сарын бэлгэдэл ном багтсан болно.



**Ч.Бямбаханд. МОНГОЛ ХЭЛНИЙ ОРОН ЦАГИЙН ХАРЬЦААНЫ НЭРИЙН УТГА, БҮТЦИЙН ОНЦЛОГ.**

Ред. М.Базаррагчаа. Уб., 2017. 264 х.

ISBN: 978-99973-76-99-2

Монгол хэлний дайвар үгийн дотор зонхилох байрыг эзлэх орон цагийн харьцааны нэрийг сонгон авч монгол хэлнээ орон цагийн утгыг илтгэх нэрийн зүйлстэй харьцуулан, орон цагийн харьцааны нэрийн утга, бүтцийн онцлогийг тодорхойлсон болно.

Орон цагийн харьцааны нэрийг авиа ба дүрс дуурайх үг, тэмдгийн нэр, угтвар бүтээвэр, сул баймжит бүтээвэр, баймж үгээс ялган, түүнийг дайвар үг буюу хувилах ба үгсийн завсрын айн гол мөхлөг гэж үзээд, жинхэнэ нэрийн өмнө тоо ба тэмдгийн нэр, үйл үгийн өмнө авиа ба дүрс дуурайх үг хамжин орж, нэр үйлийн тодотгол болдог бол орон цагийн харьцааны нэр нь үйл үгсийн өмнө гарахын тийн ялгал, нэрийн өмнө харьяалахын тийн ялгалын

нөхцөлөөр захирагдаж, орон цагийн утгатын ялгалын саармагшсан тэг хувилбарыг далд агуулах болсон нь завсрын шинжийг илтгэсэн “царцмал” ай болж орон цагийн утгыг өгүүлбэрийн үйл явдалд нэлэнхүйд хамааруулах үүднээс заримдаг буюу дутмаг хувилах шинжтэй байна.

Иймд заримдаг буюу дутмаг хувилах үгс нь өөрийгөө бүтээх зохих дагавартай бөгөөд утгын хувьд орон цагийн харьцааны нэр болох тул дангаараа дайвар үгийн айг бий болгодог. Тиймээс үйл үгийн өмнө хамжин (зарим тохиолдолд найран) орсон бүх үгийг дайвар үг гэх бүлэгт багтаан үзэлгүй түүнээс орон цагийн харьцааны нэрийг тусгайлан авч үзсэн болно